



МОНГОЛЫН ХУУЛЬЧДЫН ХОЛБООНЫ ИХ ХУРЛЫН ТӨЛӨӨЛӨГЧ СОНГОХ ЖУРАМ

**Улаанбаатар хот
2015 он**

МОНГОЛЫН ХУУЛЬЧДЫН ХОЛБООНЫ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2015 оны 9 дүгээр
сарын 5-ны өдөр

Дугаар 21

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.7, 48.10, Монголын Хуульчдын холбооны дүрмийн 4.6 дугаар зүйлийн 4, 4.10 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг тус тус удирдлага болгон Хуульчдын холбооны зөвлөлөөс ТОГТООХ нь:

1.Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.5 дахь хэсэг, 48 дугаар зүйлийн 48.9.12 дахь заалт, Монголын Хуульчдын холбооны дүрмийн 3.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийг тус тус үндэслэн “Монголын Хуульчдын холбооны Их хурлын төлөөлөгч сонгох журам”-ыг хавсралтаар баталсугай.

2.Энэ тогтоолыг 2015 оны 9 дүгээр сарын 5-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

ХУРАЛ ДАРГАЛАГЧ

Д.БАТСҮХ

АГУУЛГА

Нэгдүгээр бүлэг.	Нийтлэг үндэслэл	4
Хоёрдугаар бүлэг.	Сонгууль зохион байгуулах ажлын хэсэг, түүний зохион байгуулалт, чиг үүрэг	7
Гуравдугаар бүлэг.	Сонгуульд оролцох эрх бүхий хуульчдын нэрсийн жагсаалт	8
Дөрөвдүгээр бүлэг.	Их хурлын төлөөлөгчид нэр дэвшүүлэх, нэр дэвшигчийг бүртгэх	10
Тавдугаар бүлэг.	Их хурлын төлөөлөгчийг сонгох, сонгуулийн дүн гаргах, төлөөлөгчдийн нэрсийн жагсаалт гаргах	10
Зургадугаар бүлэг.	Бусад зүйл.....	13

МОНГОЛЫН ХУУЛЬЧДЫН ХОЛБООНЫ ИХ ХУРЛЫН ТӨЛӨӨЛӨГЧ СОНГОХ ЖУРАМ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1 дүгээр зүйл. Журмын зорилт

1. Энэ журмын зорилт нь хуульчдаас Хуульчдын холбооны Их хурал /цаашид “Их хурал” гэх/-д оролцох төлөөлөгчийг сонгох үндсэн зарчим, журмыг тодорхойлох, Их хурлын төлөөлөгчид нэр дэвших, сонгох, сонгогдох эрхийг хангах, Их хурлын төлөөлөгчийг сонгох сонгуулийг зохион байгуулж, явуулахтай холбоотой харилцааг зохицуулахад оршино.

1.2 дугаар зүйл. Нэр томъёоны тодорхойлолт

1. Энэ журамд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

1.1. “хувийн бүртгэл” гэж www.mqlbar.mn цахим хуудсанд байрлах хуульчдын нэгдсэн бүртгэлийн сан дахь хуульчийн хувийн мэдээллийг агуулсан бүртгэлийг;

1.2. “нэр дэвшигч” гэж Их хуралд оролцохоо илэрхийлж, нэр дэвшигчдийн нэрсийн жагсаалтад бүртгэгдсэн хуульчийг;

1.3. “сонгууль” гэж Их хуралд оролцох хуульчдын төлөөллийг сонгох үйл ажиллагааг;

1.4. “санал хураалтын цахим систем” гэж www.mqlbar.mn цахим хуудсанд байрлах нэр дэвшүүлэх, санал авах, сонгуулийн дүнг тооцоолох программыг;

1.5. “төлөөлөгч” гэж санал хураалтын дүнгээр энэ журамд заасан төлөөлөгчдийн тоонд багтсан хуульчийг;

1.6. “сонгуульд оролцох эрх бүхий хуульч” гэж хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл нь түдгэлзэгдээгүй байгаа хуульчийг;

1.7. “бусад хуульч” гэж шүүгч, прокурор, өмгөөлөгч, нотариатчдаас бусад хуульчийг.

[/Энэ зүйлийг Монголын Хуульчдын холбооны зөвлөлийн 2022 оны 2 дугаар сарын 18-ны өдрийн хурлын 5 дугаар тогтоолоор өөрчлөлт оруулсан/](#)

2. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт тодорхойлсон нэр томъёог гагцхүү энэ журмын хүрээнд хэрэглэнэ.

1.3 дугаар зүйл. Их хурлын төлөөлөгчдийн сонгууль

1. Их хурлын төлөөлөгчдийн сонгууль /цаашид “Сонгууль” гэх/ нь Хуульчдын холбооны эрх барих дээд байгууллага болох Их хурлын төлөөлөгчдийг бүрдүүлэх үндсэн арга мөн.

2. Сонгууль нь ээлжит болон ээлжит бус сонгууль гэсэн төрөлтэй байна.

3. “Ээлжит Их хурлын төлөөлөгч сонгох сонгууль” гэж Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.3 дахь хэсэгт зааснаар хоёр жил тутам явагдаж байгаа сонгуулийг хэлнэ.

4. Ээлжит Их хурлын төлөөлөгч сонгох сонгуулийг энэ зүйлийн 3 дахь хэсэгт заасан хугацаанд заавал явуулах бөгөөд давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдлаас бусад тохиолдолд энэ зүйлийн 3 дахь хэсэгт заасан хугацааг өөрчлөхийг хориглоно.

5. “Ээлжит бус Их хурлын төлөөлөгч сонгох сонгууль” гэж Монгол Хуульчдын холбооны дүрэм/цаашид “Холбооны дүрэм” гэх/-ийн 3.2 дугаар зүйлийн 6 дахь хэсэгт зааснаар зохион байгуулагдах Их хурлын төлөөлөгчийг сонгох сонгуулийг хэлнэ.

6. Их хурлын төлөөлөгчийн тоог Монголын Хуульчдын холбооны зөвлөл /цаашид “Зөвлөл” гэх/ тогтооно.

7. Их хурлын төлөөлөгчдийн тоог сонгуулийн нэгдсэн дүн гарсны дараа хуульчдын нэгдсэн бүртгэлд бүртгэлтэй байгаа нийт хуульчдын тооноос шүүгч, прокурор, өмгөөлөгч, нотариатч, бусад хуульчдын төлөөлөл тус бүр 20 хувь байхаар Холбооны дүрмийн 3.3 дугаар зүйлд заасан хувь, хэмжээг харгалзан тогтооно.

[/Энэ зүйлийг Монголын Хуульчдын холбооны зөвлөлийн 2022 оны 2 дугаар сарын 18-ны өдрийн хурлын 5 дугаар тогтоолоор өөрчлөлт оруулсан/](#)

1.4 дүгээр зүйл. Төлөөлөгчийг сонгох үндсэн зарчим

1. Их хурлын төлөөлөгчийг энэ журмын 3.1 дүгээр зүйлийн 1-д заасан төлөөллийн хэсэг тус бүрээр, чөлөөтэй, шууд сонгох эрхийн үндсэн дээр саналаа нууцаар гаргаж сонгох эрхийг хангахад үндэслэнэ.

2. Сонгууль бүх хуульчдын байх бөгөөд түүнд сонгуульд оролцох эрх бүхий хуульч бүрийн оролцох эрх нээлттэй байна.

3. Хуульч сонгуульд шууд сонгох эрхийнхээ үндсэн дээр ямар нэг төлөөлөлгүйгээр оролцож, саналаа өөрөө гаргана.

4. Сонгууль нь чөлөөтэй байх бөгөөд хуульчаас сонгуульд оролцох эсэхээ бие даан шийдвэрлэх, саналаа чөлөөтэй илэрхийлэхэд хэн боловч албадан нөлөөлж, саад учруулахыг хориглоно.

5. Хуульч санал хураалтын цахим системийн тусламжтайгаар саналаа нууцаар гаргах ба хөндлөнгийн нөлөөгүйгээр хүсэл зоригоо илэрхийлж, саналаа гаргах боломжийг өөрөө хангасан байна.

1.5 дугаар зүйл. Хуульчийн сонгох, сонгогдох эрх

1. Сонгуульд хуульч үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор ялгаварлагдахгүйгээр оролцох эрхтэй.

2. Их хурлын товыг тогтоосон шийдвэр гарах өдөр хуульчдын нэгдсэн бүртгэлд бүртгэлтэй байгаа хуульч Их хурлын төлөөлөгчөөр сонгогдох эрхтэй.

3. Өөрийн хүсэлтээр эсхүл Хуульчдын холбооны Мэргэжлийн хариуцлагын хорооны шийдвэрээр хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл нь түдгэлзсэн хуульч сонгуульд оролцох эрх эдлэхгүй.

1.6 дугаар зүйл. Их хурлын төлөөлөгчид нэр дэвшүүлэх эрх

1. Хуульч нь Их хуралд оролцох хүсэл зоригоо илэрхийлж, гагцхүү өөрийгөө сонгуульд нэр дэвшүүлнэ.

2. Хуульч нь санал хураалтын цахим систем дэх хувийн бүртгэлдээ нэвтэрч “нэр дэвших” гэсэн тэмдэглэгээг сонгож дарснаар сонгуульд нэр дэвших эрх баталгаажина.

3. Хуульч нь нэр дэвшихээ илэрхийлж тэмдэглэгээ хийхдээ өөрийн хувийн бүртгэлд

зураг ба танилцуулга, бусад мэдээлэл оруулж болно.

1.7 дугаар зүйл. Сонгууль товлон зарлах

1. Сонгуулийг Их хурлын тов тогтоосон шийдвэр гарсан өдрөөс хойш арван дөрөв хоногийн дотор Зөвлөл товлон зарлана.

1.8 дугаар зүйл. Сонгууль явуулах хугацаа, үе шат

1. Сонгуулийг дараах үе шат, хугацаагаар явуулна:

- 1.1. Их хурлын төлөөлөгчид нэр дэвшүүлэх ажиллагааг дөрөв хоногт;
- 1.2. Төлөөлөгчийг сонгох ажиллагааг гурав хоногт.

1.9 дүгээр зүйл. Сонгууль зохион байгуулахад баримтлах зарчим

1. Сонгууль зохион байгуулах Холбооны бүтцийн нэгж, ажлын хэсэг, тэдгээрт ажиллаж байгаа албан тушаалтан, гишүүн болон бусад хуульч сонгуулийн үйл явцыг зохион байгуулах, түүнд оролцохдоо дараах зарчмыг баримтална:

- 1.1. хууль дээдлэх;
- 1.2. ил тод байдлыг хангах;
- 1.3. шударга ёсыг сахих;
- 1.4. маргааныг шуурхай, үндэслэлтэй, шударга шийдвэрлэх.

2. Сонгууль зохион байгуулах, түүний бэлтгэл ажилтай холбогдуулан ажлын хэсэгт энэ журмаар олгосон эрхийн хүрээнд гаргасан шийдвэрийг Холбооны хэвлэл мэдээллийн хэрэгслээр албан ёсоор мэдээлсэн байна.

3. Сонгууль зохион байгуулах ажлын ил тод байдлыг хангах зарчим нь хуульч саналаа нууцаар гаргахад хамаарахгүй.

4. Холбоо, түүний бүтцийн нэгж, тэдгээрт ажиллаж буй албан тушаалтан болон бусад хуульч сонгуулийн үйл ажиллагааны талаар үнэн зөв, бодитой мэдээлэл түгээх үүрэгтэй.

1.10 дугаар зүйл. Сонгуулийн үйл ажиллагаатай холбоотой мэдээлэл өгөх

1. Сонгуулийн үйл ажиллагаатай холбоотой Хуульчийн эрх зүйн байдлын тухай, Холбооны дүрэм, энэ журамд заасан холбогдох мэдээллийг Ажлын хэсэг тухай бүр өгч ажиллана.

2. Мэдээллийг олон нийтийн болон Холбооны мэдээллийн хэрэгсэл, тухайн хуульчийн Холбоонд бүртгэлтэй утас, цахим шуудангийн хаягийг ашиглан хүргэнэ.

1.11 дүгээр зүйл. Санал хураалтын цахим систем

1. Санал хураалтын цахим систем нь хуульч Их хурлын төлөөлөгчид нэр дэвшүүлэх, түүнийг баталгаажуулах, төлөөлөгчийг сонгох саналаа илэрхийлэх, түүнийг нь баталгаажуулах, сонгуулийн дүнг нэгтгэн гаргахаар программчилагдсан сонгуулийн үндсэн хэрэгсэл мөн бөгөөд дараах шаардлагыг хангасан байна:

- 1.1. хуульч нэрээ дэвшүүлэх, санал өгөх хэсгийн агуулга, бичилт, хэлбэр нь хуульчаас саналаа илэрхийлэхэд хялбар, ойлгомжтой байх;
- 1.2. хуульч саналаа хэрхэн тэмдэглэх тухай товч заавар агуулсан байх.

1.12 дугаар зүйл. Санал хураалтын цахим системийг ашиглах

1. Хуульч бүр www.mglbar.mn цахим хуудсанд хувийн бүртгэлтэй байх бөгөөд өөрийн регистрийн дугаар болон нууц үгээр нэвтэрнэ.

2.Хувийн бүртгэлд анх нэвтрэх нууц үгийг тохиолдлын байдлаар үүсгэн хуульчдын нэгдсэн бүртгэлийн санд бүртгэгдсэн хуульчийн гар утасны дугаарт илгээнэ. Хуульч энэ нууц үгийг өөрчилж хадгалж болно. Хэрэв өөрчилж хадгалах бол нэвтрэх шинэ нууц үг нь 10 ба түүнээс дээш тэмдэгттэй байх бөгөөд заавал тоо, үсгээр бүрдэнэ.

3.Хуульч нь хувийн бүртгэлдээ нэвтэрч нэр дэвших, санал өгөх байдлаар сонгуульд оролцоно.

1.13 дугаар зүйл.Сонгуулийн үйл ажиллагааны санхүүжилт

1.Сонгууль зохион байгуулахтай холбогдсон дор дурдсан зардлыг Холбоо санхүүжүүлнэ:

1.1.Сонгууль зохион байгуулах ажлын хэсгийн зардал, сонгуулийг явуулах цахим системийн найдвартай ажиллагааг хангах, программ хангамжийн хэвийн ажиллагааны хяналт засварын ажлын зардал, сонгуульд оролцох эрх бүхий хуульчдын нэрсийн жагсаалт, сонгуулийн дүн, мэдээний маягт, сонгуулийн ажиллагаанд хэрэглэх техник, тоног төхөөрөмж, программ хангамж, болон тэдгээрийг худалдан авах, түрээслэх, ашиглах, хамгаалах, хадгалах, засвар үйлчилгээ хийх, хэвлэх, үйлдвэрлэх, тээвэрлэх, хүргэх зардал;

1.2.сонгууль зохион байгуулахтай холбогдсон эрх зүйн бусад акт, гарын авлага хэвлэх, хүргэх зардал;

1.3.сонгууль зохион байгуулах, түүний бэлтгэл ажлын явц, хугацааны талаар сонгуульд оролцох эрх бүхий хуульчдыг мэдээллээр хангах үйл ажиллагааны зардал;

1.4.онцгой нөхцөл байдал үүссэн үед гарч болзошгүй зардал;

1.5.Зөвлөлөөс баталсан бусад зардал.

2.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан Холбооноос санхүүжүүлэх зардлын хэмжээг Тамгын газрын саналыг үндэслэн Их хурал зохион байгуулах зардалд багтаан Зөвлөл тухай бүр батална.

3.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан зардлын гүйцэтгэлд Хуульчдын холбооны Хяналтын зөвлөл шалгалт хийж, дүгнэлт гаргана.

ХОЁРДУГААР БҮЛЭГ СОНГУУЛЬ ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН ХЭСЭГ, ТҮҮНИЙ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ЧИГ ҮҮРЭГ

2.1 дүгээр зүйл.Сонгууль зохион байгуулах ажлын хэсэг

1.Зөвлөлөөс байгуулагдсан Их хурал зохион байгуулах ажлын хэсэг /цаашид “Ажлын хэсэг” гэх/ Холбооны хэмжээнд Их хурлын төлөөлөгчийг сонгох сонгуулийн үйл ажиллагааг эрхлэн зохион байгуулна.

2.Ажлын хэсэгт Хуульчдын холбооны Тамгын газар /цаашид “Тамгын газар” гэх/ болон шүүгч, прокурор, өмгөөлөгч, нотариатч, бусад хуульчдын төлөөллийг заавал оролцуулна.

[/Энэ зүйлийг Монголын Хуульчдын холбооны зөвлөлийн 2022 оны 2 дугаар сарын 18-ны өдрийн хурлын 5 дугаар тогтоолоор нэмсэн/](#)

3.Ажлын хэсгээс сонгууль зохион байгуулах, энэ журмын биелэлтийг ханган ажиллахад Холбоо, түүний бүтцийн нэгж, холбогдох тушаалтан шаардлагатай дэмжлэг туслалцаа үзүүлэн ажиллана.

2.2 дугаар зүйл.Ажлын хэсгийн чиг үүрэг

1.Ажлын хэсэг дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

1.1.сонгууль зохион байгуулах ажлыг төлөвлөх, түүнийг зохион байгуулах арга хэмжээг авах;

- 1.2.сонгуультай холбоотой хууль, Холбооны дүрэм болон энэ журмын биелэлтийг ханган ажиллах;
- 1.3.холбооны холбогдох мэргэжилтэн, ажилтны үйл ажиллагааг зохион байгуулалт, арга зүйн нэгдсэн удирдлагаар хангах;
- 1.4.Зөвлөлөөс хуваарилсан төсвийн хөрөнгийг зориулалтын дагуу захиран зарцуулах шийдвэр гаргах, зарцуулалтад нь хяналт тавих;
- 1.5.сонгуульд оролцох эрх бүхий хуульчдын нэрсийн жагсаалтыг энэ журамд заасан төлөөллийн хэсэг тус бүрээр сонгуулийн системд бүртгэгдсэн эсэхийг шалгаж, баталгаажуулах;
- 1.6.сонгууль зохион байгуулахтай холбогдсон асуудлаар Холбоо, түүний бүтцийн нэгжийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, харилцан мэдээлэл солилцох, шаардлагатай арга хэмжээ авах;
- 1.7.хуульчийн бүртгэл, нэр дэвшүүлэх, санал өгөх үйл ажиллагаатай холбоотой асуудлын шийдвэрийн талаарх өргөдөл, гомдлыг хянан шийдвэрлэж хариу өгөх;
- 1.8.санал хураалтын дүнг нэгтгэж, Зөвлөлд хүргүүлэх;
- 1.9.сонгуультай холбоотой баримт бичгийг зохих журмын дагуу цэгцэлж, Тамгын газарт хүлээлгэн өгөх;
- 1.10.сонгууль зохион байгуулахтай холбогдуулан Зөвлөлөөс өгсөн хууль ёсны үүргийг биелүүлэх;
- 1.11.энэ журамд заасан бусад чиг үүрэг.

2.3 дугаар зүйл.Ажлын хэсгийн зохион байгуулалтын хэлбэр

- 1.Ажлын хэсэг чиг үүрэгтээ хамаарах асуудлыг хуралдаанаараа хэлэлцэж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар шийдвэрлэж, тогтоол гаргана.
- 2.Хуралдаанд гишүүдийн олонх оролцсон бол тухайн ажлын хэсгийн хуралдааныг хүчинтэйд тооцно.
- 3.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан тогтоолд ажлын хэсгийн дарга, нарийн бичгийн дарга гарын үсэг зурна.
- 4.Ажлын хэсгийн хуралдаанд Монголын Хуульчдын холбооны зөвлөлийн ажиллах журмын 2.2 дугаар зүйлд заасан дэгийг баримтлах бөгөөд үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдал, гишүүдийн ажил үүргийн хуваарь, ажиллах зарчимд нийцүүлэн ажиллана.
- 5.Ажлын хэсгийн хуралдааны шийдвэрийг хуульчдад ил тод мэдээлнэ.
- 6.Ажлын хэсгийн хуралдааны явцыг тэмдэглэл үйлдэн баталгаажуулах бөгөөд тэмдэглэлийг ажлын хэсгийн нарийн бичгийн дарга хөтөлнө.
- 7.Ажлын хэсгээс сонгууль зохион байгуулахтай холбогдсон, түүнчлэн хууль, дүрмийн зохицуулалтыг зөрчсөн тухай асуудлыг шалгуулах, эсхүл зөрчлийг таслан зогсоох асуудлаар Холбооны холбогдох бүтцийн нэгж, албан тушаалтанд хууль ёсны шаардлага тавих эрхтэй бөгөөд түүнийг хүлээн авсан бүтцийн нэгж, албан тушаалтан тавьсан асуудлыг богино хугацаанд шийдвэрлэж, хариу мэдэгдэнэ.

ГУРАВДУГААР БҮЛЭГ СОНГУУЛЬД ОРОЛЦОХ ЭРХ БҮХИЙ ХУУЛЬЧДЫН НЭРСИЙН ЖАГСААЛТ

3.1 дүгээр зүйл.Сонгуульд оролцох хуульчдын нэрсийн жагсаалт үйлдэх, танилцуулах

- 1.Сонгуульд оролцох эрх бүхий хуульчдын нэрсийн жагсаалтыг Хуульчдын холбооны нэгдсэн бүртгэл, мэдээллийн санд үндэслэн дор дурдсан төлөөллийн хэсэг тус бүрээр үйлдэх бөгөөд түүнийг нягтлан шалгах, давхардлыг арилгах зэрэг ажлыг Холбооны тухайн асуудлыг хариуцсан нэгж, албан тушаалтантай хамтран зохион байгуулж, нэгдсэн

удирдлагаар хангана.

- 1.1.шүүгчдийн төлөөллийн хэсэг;
- 1.2.прокурорын төлөөллийн хэсэг;
- 1.3.өмгөөлөгчдийн төлөөллийн хэсэг;
- 1.4.бусад хуульчдын төлөөллийн хэсэг.
- 1.5.нотариатчдын төлөөллийн хэсэг.

[/Энэ зүйлийг Монголын Хуульчдын холбооны зөвлөлийн 2022 оны 2 дугаар сарын 18-ны өдрийн хурлын 5 дугаар тогтоолоор нэмсэн/](#)

2.Сонгуульд оролцох эрх бүхий хуульчдын нэрсийн жагсаалтад тухайн төлөөллийн хэсэгт хамаарах хуульчийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, хуульчдын нэгдсэн бүртгэлийн дугаар, хамаарагдах төлөөллийн хэсгийн нэр байх бөгөөд ийнхүү бүртгэхдээ хуульчийн нэрийн үсгийн дарааллаар бичнэ.

3.Тамгын газар сонгуульд оролцох эрх бүхий хуульчдын нэрсийн жагсаалтыг сонгууль эхлэхээс гурваас доошгүй хоногийн өмнө сонгуулийн цахим системд байрлуулсан байна.

4.Хуульч энэ зүйлийн 3 дахь хэсэгт заасан нэрсийн жагсаалтад бүртгэгдсэн эсэхээ нэр дэвшүүлэх өдөр эхлэхээс таваас доошгүй хоногийн өмнө шалгасан байна.

5.Ажлын хэсэг энэ зүйлийн 3 дахь хэсэгт заасны дагуу цахим системд байршуулсан хуульчдын нэрсийн жагсаалтад оруулах дараах өөрчлөлтийн талаар нэр дэвшүүлэх ажиллагаа эхлэх өдрөөс нэг хоногийн өмнө хуралдаанаараа хэлэлцэж шийдвэрлэсэн байна:

- 5.1.хуульчаас энэ зүйлийн 3 дахь хэсэгт заасан нэрсийн жагсаалтад бүртгэгдээгүй буюу буруу бүртгэгдсэн талаар гаргасан гомдлын дагуу оруулсан өөрчлөлт;
- 5.2.энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан мэдээлэлтэй холбогдсон өөрчлөлт;
- 5.3.хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл түдгэлзсэн бүртгэлтэй холбогдсон өөрчлөлт.

6.Энэ зүйлийн 5 дахь хэсэгт зааснаас бусад үндэслэлээр сонгуульд оролцох эрх бүхий хуульчдын нэрсийн жагсаалтад өөрчлөлт оруулахыг хориглоно.

7.Ажлын хэсэг энэ зүйлийн 5 дахь хэсэгт заасан өөрчлөлтийг төлөөллийн хэсэг тус бүрээр гаргах бөгөөд төлөөллийн хэсэг бүрт хамрагдах хуульчдын нэрсийн жагсаалтыг гаргаж, нэр дэвшүүлэх ажиллагаа эхлэхээс 12 цагийн өмнө Тамгын газарт хүргүүлсэн байна.

8.Тамгын газар энэ зүйлийн 7 дахь хэсэгт заасан хуульчдын нэрсийн жагсаалтыг төлөөллийн хэсэг тус бүрээр ангилж, цахим системд нэр дэвшүүлэх ажиллагаа эхлэхээс өмнө оруулсан байна.

9.Ажлын хэсэг энэ зүйлийн 5 дахь хэсэгт заасан өөрчлөлтийг бүртгэсэн эцсийн нэрсийн жагсаалтыг төлөөллийн хэсэг тус бүрээр баталгаажуулж, тогтоол гаргана.

3.2 дугаар зүйл.Нэрсийн жагсаалтын талаарх гомдлыг шийдвэрлүүлэх журам

1.Хуульч өөрийн нэр энэ журмын 3.1 дүгээр зүйлд заасан нэрсийн жагсаалтад бүртгэгдээгүй, эсхүл буруу төлөөллийн хэсэгт бүртгэгдсэн байвал энэ тухай гомдлоо нэр дэвшүүлэх ажиллагаа эхлэхээс хоёроос доошгүй хоногийн өмнө ажлын хэсэгт бичгээр болон цахимаар гаргана.

2.Ажлын хэсэг энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан гомдлыг хүлээн авсан бол тухайн гомдол гаргасан хуульчийн мэдээллийг Хуульчдын холбооны бүртгэл, мэдээллийн нэгдсэн сангаас хайлт хийн тодорхойлж, лавлагаа гаргах ба тухайн лавлагааг үндэслэн энэ журмын 3.1 дүгээр зүйлийн 5 дахь хэсэгт заасан журмаар шийдвэрлэсэн байна.

3.Нэр дэвшүүлэх ажиллагаа эхэлсэн өдрөөс хойш энэ зүйлийн 1, 2 дахь хэсэгт заасан ажиллагаа хийхийг хориглоно.

3.3 дугаар зүйл.Хуульчийн төлөөллийн хэсгийг шилжүүлэх

1.Хуульч өөрийн эрхэлж байгаа албан тушаал, явуулж байгаа үйл ажиллагаанаасаа хамаарч энэ журмын 3.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан төлөөллийн хэсгийн нэрсийн жагсаалтад бүртгэгдэх ба тухайн төлөөллийн хэсэгтээ нэр дэвшүүлж, сонгох санал өгнө.

2.Төлөөллийн хэсгийн шилжилтийг нэр дэвшүүлэх ажиллагаа дуусах өдрийн 18.00 цагаас эхлэн зогсоох бөгөөд тухайн хуульч Их хурлын төлөөлөгчид нэрээ дэвшүүлж болохгүй.

3.Хуульч нэр дэвшүүлэх ажиллагаа эхлэхээс өмнө өөр төлөөллийн хэсэгт шилжих бол үндэслэл бүхий хүсэлтээ холбогдох баримтын хамт Ажлын хэсэгт бичгээр гаргах бөгөөд ажлын хэсэг энэ журмын 3.1 дүгээр зүйлийн 5 дахь хэсэгт заасан журмын дагуу шийдвэрлэнэ.

4.Хуульч энэ зүйлийн 3 дахь хэсэгт заасан журмын дагуу хүсэлт гаргасан бол холбогдох шийдвэрийг үндэслэн төлөөллийн хэсгийг ажлын хэсгийн хуралдаанаар хэлэлцэж дараах байдлаар шийдвэрлэнэ:

4.1.шүүгч, прокурорын албан тушаалаас чөлөөлөгдсөн, өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх эрх, нотариатын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг түдгэлзүүлсэн, хүчингүй болсон бол бусад хуульчийн төлөөллийн хэсэгт бүртгэхээр;

[/Энэ зүйлийг Монголын Хуульчдын холбооны зөвлөлийн 2022 оны 2 дугаар сарын 18-ны өдрийн хурлын 5 дугаар тогтоолоор өөрчлөлт оруулсан/](#)

4.2.шүүгчээр томилогдсон бол шүүгчдийн төлөөллийн хэсэгт бүртгэхээр;

4.3.прокуророор томилогдсон бол прокурорын төлөөллийн хэсэгт бүртгэхээр;

4.4.өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх эрх авсан бол өмгөөлөгчдийн төлөөллийн хэсэгт бүртгэхээр.

4.5.нотариатын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авсан бол нотариатчдын төлөөллийн хэсэгт бүртгэхээр.

[/Энэ зүйлийг Монголын Хуульчдын холбооны зөвлөлийн 2022 оны 2 дугаар сарын 18-ны өдрийн хурлын 5 дугаар тогтоолоор нэмсэн/](#)

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ ИХ ХУРЛЫН ТӨЛӨӨЛӨГЧИД НЭР ДЭВШҮҮЛЭХ, НЭР ДЭВШИГЧИЙГ БҮРТГЭХ

4.1 дүгээр зүйл.Нэр дэвшүүлэх нийтлэг журам

1.Их хурлын төлөөлөгчид нэр дэвшүүлэх ажиллагааг сонгууль эхэлсэн өдрөөс хойш дөрөв хоногийн дотор явуулна.

2.Их хурлын тов тогтоосон шийдвэр гарсан өдөр хуульчдын нэгдсэн бүртгэлд бүртгэгдсэн, хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл нь түдгэлзэгдээгүй байгаа хуульч бүрийг нэр дэвшигч гэж үзнэ.

3.Хуульч бүр Их хурлын төлөөлөгчид өөрөө нэрээ дэвшүүлэх эрхтэй бөгөөд шүүгч нь шүүгчдийн төлөөллийн хэсэгт, прокурор нь прокуроруудын төлөөллийн хэсэгт, өмгөөлөгч нь өмгөөлөгчдийн төлөөллийн хэсэгт, нотариатч нь нотариатчдын төлөөллийн хэсэгт, эдгээрээс бусад хуульч нь бусад хуульчдын төлөөллийн хэсэгт тус тус нэрээ дэвшүүлнэ.

[/Энэ зүйлийг Монголын Хуульчдын холбооны зөвлөлийн 2022 оны 2 дугаар сарын 18-ны өдрийн хурлын 5 дугаар тогтоолоор нэмсэн/](#)

4.2 дугаар зүйл.Нэр дэвшүүлэх хэлбэр, хугацаа

1.Их хурлын төлөөлөгчид нэр дэвшүүлэх ажиллагаа цахим хэлбэрээр явагдах бөгөөд хуульч санал хураалтын цахим систем дэх хувийн бүртгэлдээ нэвтэрч “нэр дэвших” гэсэн тэмдэглэгээг сонгож дарснаар сонгуульд нэрээ дэвшүүлнэ.

2.Нэр дэвшүүлэх ажиллагааг тухайн ажиллагаа явуулах эхний өдрийн 08.00 цагаас, эхлүүлж, ажиллагаа дуусах сүүлийн өдрийн 22.00 цаг хүртэлх хугацаанд www.mglbar.mn цахим хуудасны санал хураалтын цахим системийг ашиглан зохион байгуулна.

4.3 дугаар зүйл.Нэр дэвшигч өөрийгөө сурталчилах

1.Хуульч Их хурлын төлөөлөгчид нэрээ дэвшүүлж тэмдэглэгээ хийхдээ өөрийн хувийн бүртгэлд зураг ба таницуулга, бусад мэдээлэл оруулах хэлбэрээр сурталчилгаа хийж болно.

2.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт зааснаас өөр хэлбэрээр сурталчилгаа явуулж болохгүй.

ТАВДУГААР БҮЛЭГ ИХ ХУРЛЫН ТӨЛӨӨЛӨГЧИЙГ СОНГОХ, СОНГУУЛИЙН ДҮН ГАРГАХ, ТӨЛӨӨЛӨГЧДИЙН НЭРСИЙН ЖАГСААЛТ ГАРГАХ

5.1 дүгээр зүйл.Санал өгөх хэлбэр

1.Их хурлын төлөөлөгчийг сонгох санал өгөхөд санал хураалтын цахим системийг ашиглана.

2.Санал хураалтын цахим систем нь шүүгч, прокурор, өмгөөлөгч, нотариатч, бусад хуульч гэсэн хэсэгтэй байх бөгөөд шүүгчийн хэсэгт шүүгчээр томилогдон ажиллаж байгаа хуульчдын, прокурорын хэсэгт прокуророор томилогдон ажиллаж байгаа хуульчдын, өмгөөлөгчийн хэсэгт өмгөөлөгчдийн нэрсийн жагсаалтад бүртгэгдсэн хуульчдын, нотариатчдын хэсэгт нотариатын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй хуульчдын, бусад хуульчдын хэсэгт шүүгч, прокурор, өмгөөлөгчөөр ажиллаж байгаагаас бусад хуульчдын нэрсийн жагсаалтыг тус тус оруулсан байна.

[/Энэ зүйлийг Монголын Хуульчдын холбооны зөвлөлийн 2022 оны 2 дугаар сарын 18-ны өдрийн хурлын 5 дугаар тогтоолоор өөрчлөлт оруулсан/](#)

3.Цахим системийн шүүгчдийн хэсэгт шүүгч, прокурорын хэсэгт прокурор, өмгөөлөгчдийн хэсэгт өмгөөлөгч, нотариатчдын хэсэгт нотариатч, бусад хуульчдын хэсэгт бусад хуульч нэвтэрч саналаа өгөхөөр зохион байгуулагдсан байна.

[/Энэ зүйлийг Монголын Хуульчдын холбооны зөвлөлийн 2022 оны 2 дугаар сарын 18-ны өдрийн хурлын 5 дугаар тогтоолоор нэмсэн/](#)

4.Санал хураалтын цахим систем дэх нэр дэвшигчдийн жагсаалтыг тохиолдлын байдлаар дарааллуулсан хуульч бүрт өөр харагдахаар тохируулсан байна.

5.2 дугаар зүйл.Санал өгөх хугацаа, түүнийг зохион байгуулах

1.Санал өгөх ажиллагааг санал өгөх эхний өдрийн 08.00 цагаас эхэлж, санал өгөх сүүлийн өдрийн 22.00 цаг хүртэлх хугацаанд www.mglbar.mn цахим хуудасны санал хураалтын цахим системийг ашиглан зохион байгуулна.

5.3 дугаар зүйл.Санал хураалтын цахим системийн тохиргоо

1.Санал хураалтын цахим систем нь “төлөөлөгчид нэр дэвшүүлэх”, “төлөөлөгчийг сонгох”, “санал хураалтыг тоолж, дүнг гаргах” тохиргоотой байна.

5.4 дүгээр зүйл.Нэр дэвшүүлэх, санал өгөх ажиллагаа

1.Хуульч Их хурлын төлөөлөгчид нэр дэвшүүлэх, төлөөлөгчийг сонгох зэргээр сонгуульд оролцохдоо өөрийн бүртгэлийн нэр, нууц үгээр нэвтрэх www.mglbar.mn цахим хуудасны “гишүүний булан” дэд хэсгийг ашиглана.

2.Их хурлын төлөөлөгчид нэр дэвшүүлэх ажиллагаа нь дараах үе шаттайгаар явагдана:

2.1.“гишүүний булан” дэд хэсэгт нэвтэрсний дараа “сонгууль, санал асуулга” гэсэн хэсэгт нэвтэрнэ;

2.2.“сонгууль, санал асуулга” хэсэг нь “сонгуулийн нэр”, “эхлэх, дуусах хугацаа”, “санал өгөх” гэсэн мэдээллийг агуулсан байх бөгөөд энэ хэсгийн “санал өгөх” цонхыг дарж, дараагийн шатанд шилжинэ;

2.3.дараагийн шат нь “сонгуульд нэр дэвшүүлэх” хэсэг байх ба хуульч “нэр дэвшүүлэх” гэсэн цонхыг дарж идэвхжүүлнэ;

2.4.хуульч “нэр дэвшүүлэх” гэсэн цонхыг идэвхжүүлсний дараа “баталгаажуулах” товчийг дарснаар нэр дэвшүүлэх ажиллагаа баталгаажина.

3.Их хурлын төлөөлөгчид нэр дэвшигчийг сонгох санал өгөх ажиллагаа нь дараах үе шаттайгаар явагдана:

3.1.“гишүүний булан” дэд хэсэгт нэвтэрсний дараа “сонгууль, санал асуулга” гэсэн хэсэгт нэвтэрнэ;

3.2.“сонгууль, санал асуулга” хэсэг нь “сонгуулийн нэр”, “эхлэх, дуусах хугацаа”, “санал өгөх” гэсэн мэдээллийг агуулсан байх бөгөөд энэ хэсгийн “санал өгөх” цонхыг дарж, дараагийн шатанд шилжинэ;

3.3.дараагийн шат нь “Их хурлын төлөөлөгчийг сонгох” хэсэг байх бөгөөд тухайн хуульчийн бүртгэлтэй төлөөллийн хэсгээс Их хурлын төлөөлөгчид нэрээ дэвшүүлсэн хуульчдын нэрсийн жагсаалтаас өөрийн сонгох хуульчийнхаа нэрийн өмнөх цонхыг идэвхжүүлнэ;

3.4.хуульч өөрийн харьяалагдах төлөөллийн хэсгээс Их хуралд сонгогдох төлөөлөгчдийн тоонд багтаан тэдгээрийн нэрийн өмнөх цонхыг идэвхжүүлж, “баталгаажуулах” товчийг дарснаар Их хурлын төлөөлөгчийг сонгох тухайн хуульчийн санал баталгаажна.

4.Дараах тохиолдолд нэр дэвшүүлэх ажиллагаа баталгаажихгүй:

4.1.нэр дэвшүүлэх ажиллагааны хугацаа дуусахаас өмнө “нэр дэвшүүлэх” цонхыг идэвхжүүлээгүй;

4.2.нэр дэвшүүлэх ажиллагааны хугацаа дуусахаас өмнө “нэр дэвшүүлэх” цонхыг идэвхжүүлсэн боловч баталгаажуулах товчийг дараагүй.

5.Дараах тохиолдолд Их хурлын төлөөлөгчийг сонгоход санал өгөх ажиллагаа баталгаажихгүй:

5.1.нэг ч нэр дэвшигчид санал өгөлгүйгээр баталгаажуулах товчийг дарсан;

5.2.тухайн төлөөллийн хэсгээс сонгогдох төлөөлөгчдийн тооноос олон нэр дэвшигчид санал өгсөн;

5.3.санал өгөх ажиллагааны хугацаа дуусахаас өмнө баталгаажуулах товчийг дараагүй.

6.Энэ зүйлийн 5 дахь хэсэгт зааснаар баталгаажсан тухайн хуульчийн санал нь санал хураалтын цахим системийн хэсэгт гурван сарын хугацаанд хадгалагдана.

7.Хуульч өгч буй саналынхаа нууцлалыг өөрөө хариуцна.

5.5 дугаар зүйл.Санал тоолох, дүнг гаргах

1.Санал хураалт явуулах цаг дуусмагц Их хурлын төлөөлөгчийн сонгуулийн санал тоолох ажиллагааг цахим систем автоматаар явуулж, дүнг нэгтгэн гаргах тохиргоо хийгдсэн байна.

5.6 дугаар зүйл.Сонгуулийн эцсийн дүнг гаргах, Их хурлын төлөөлөгчдийн нэрсийн жагсаалт гаргах

1.Санал хураалтын цахим систем нь тухайн төлөөллийн хэсэгт нэр дэвшигчийн авсан саналын тоогоор нь дараалалд оруулан жагсаалтыг автоматаар гаргах бөгөөд энэ журмын 1.3 дугаар зүйлийн 7 дахь хэсэгт заасан тоонд багтсан нэр дэвшигчийг Их хурлын төлөөлөгчөөр сонгогдсонд тооцно.

2.Энэ журмын 3.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан тухайн хэсгийн төлөөлөгчдийн тооны хамгийн сүүлд жагссан нэр дэвшигчийн саналын тоо нь тэнцсэн тохиолдолд тэдгээр нэр дэвшигчдийг Их хурлын төлөөлөгчөөр сонгогдсонд тооцох бөгөөд бусад төлөөллийн хэсгийн төлөөлөгчдийн тоог Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.6 дахь хэсэгт заасан хувь тэнцүүлэн нэмэгдүүлэн тогтооно.

[/Энэ зүйлийг Монголын Хуульчдын холбооны зөвлөлийн 2022 оны 2 дугаар сарын 18-ны өдрийн хурлын 5 дугаар тогтоолоор өөрчлөлт оруулсан/](#)

3.Ажлын хэсэг энэ зүйлийн 1, 2 дахь хэсэгт заасан төлөөлөгчдийн тоог төлөөллийн хэсэг тус бүрээр нэгтгэж, санал хураалтын дүн болон төлөөлөгчдийн нэрсийн жагсаалтыг 12 цагийн хоногийн дотор гарган хуралдаанаараа хэлэлцэн шийдвэр гаргаж, Зөвлөлд хүргүүлнэ.

5.7 дугаар зүйл.Сонгуулийн нэгдсэн дүн, төлөөлөгчдийн нэрсийн жагсаалтыг мэдээлэх

1.Зөвлөл энэ журмын 5.6 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасны дагуу Ажлын хэсгээс ирүүлсэн сонгуулийн дүн, төлөөлөгчдийн нэрсийн жагсаалтыг сонгууль дууссан өдрөөс хойш 24 цагийн дотор баталгаажуулж, Холбооны мэдээллийн хэрэгслээр дамжуулан хуульчдад мэдээлнэ.

ЗУРГАДУГААР БҮЛЭГ БУСАД ЗҮЙЛ

6.1 дүгээр зүйл.Хяналтын хэсэг ажиллуулах

1.Сонгуулийн зохион байгуулалт болон санал хураах цахим системийн ажиллагаанд хяналт тавих чиг үүрэг бүхий Хяналтын хэсгийг энэ журмын 3.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан төлөөллийн хэсэг бүрийн төлөөлөл болон цахим программын мэргэжилтний оролцоотойгоор Ажлын хэсгийн хуралдаанаас томилон ажиллуулна.

2.Хяналтын хэсэг нэрсийн жагсаалт үйлдэх, нэр дэвшүүлэх, санал авах, тоолох, дүн гаргах үед уг ажлыг холбогдох хууль, дүрэм, журамд заасны дагуу явуулж байгаа эсэхийг хянан шалгаж, санал, дүгнэлт гаргах бөгөөд дараах эрх эдэлнэ:

2.1.хуульчдын болон энэ журмын 3.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан төлөөллийн хэсэг бүрийн нэрсийн жагсаалттай танилцах;

2.2.санал хураалтын цахим системийн үйл ажиллагаатай танилцах;

2.3.нэр дэвшүүлэх, санал өгөх ажлын явцыг ажиглах;

2.4.сонгуулийн үйл ажиллагааны явцад зөрчил гарвал Ажлын хэсгийн даргад мэдэгдэж, залруулахыг хүсэх, илэрсэн зөрчлийн талаар тэмдэглэл хөтлөх, дуу, дүрс бичлэгийн хэрэгсэл ашиглан баталгаажуулах, тухайн асуудалтай холбоотой санал, дүгнэлт гаргах;

2.5.ажлын хэсгийн гишүүдээс холбогдох мэдээлэл авах;

2.6.сонгууль явагдаж дууссанаас хойш ажлын 3 өдөрт багтаан хяналтын тайлангаа нийтэд хуульчдад мэдээлэх, хэвлэн нийтлэх.

6.2 дугаар зүйл.Сонгуулийн журам зөрчсөн тухай гомдол, маргааныг шийдвэрлэх

1.Энэ журмыг зөрчсөнтэй холбоотой гомдлыг ажлын хэсэгт дор дурдсан хугацааны дотор гаргана:

1.1.нэр дэвшүүлэхтэй холбоотой гомдлыг нэр дэвшүүлэх ажиллагаа дуусахаас нэг хоногийн өмнө;

1.2.санал өгөхтэй холбоотой гомдлыг санал өгөх ажиллагаа дуусахаас 12 цагийн өмнө.

2.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан хугацаа өнгөрсөн бол гомдлыг хүлээн авахгүй.

6.3 дугаар зүйл.Ажлын хэсэг гомдлыг хүлээн авах, шийдвэрлэх

1.Ажлын хэсэг энэ журмын 6.2 дугаар зүйлд заасан гомдлыг хоёр хоногийн дотор, нэр дэвшүүлэх болон санал өгөх өдрийн өмнөх өдөр гомдол гаргасан бол тухайн өдөрт нь багтаан шийдвэрлэж, илэрсэн зөрчлийг арилгах арга хэмжээг бүрэн эрхийнхээ хүрээнд авна.

6.4 дүгээр зүйл.Журам хүчин төгөлдөр болох

1.Энэ журмыг 2015 оны 9 дүгээр сарын 5-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.